

4 САР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ТАЙЛАН

ОНЦЛОХ МЭДЭЭ

www.mnca.mn

976-7011 1515

МБҮА

SINCE 2009

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

Зөв зүгт Манлайлна



АГУУЛГА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

01
зАХИРГАА УДИРДЛАГА

02
АЖЛЫН АЛБА

03
ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД

04
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

05
ДУЛААН ШИЙДЭЛ

06
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТ



www.mnca.mn

2025



ЗАХИРГАА-УДИРДЛАГА

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь 2009 онд үүсгэн байгуулагдаж, өөрийн эгнээндээ барилга, бүтээн байгуулалтын салбарт идэвхтэй үйл ажиллагаагаа явуулдаг томоохон хөрөнгө оруулагч, хөгжүүлэгч, үл хөдлөх хөрөнгийн реалтор, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, архитектур, зураг төслийн чиглэлийн 160 гаруй гишүүн компаниудын бүтээн байгуулагчдыг сайн дурын үндсэн дээр нэгтгэж, гишүүддээ болон нийгэмдээ үйлчлэхээс гадна төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэдэг салбарын мэргэжлийн, манлайлагч, үндэсний бүтээн байгуулагчдын хамгийн том нэгдэл болох төрийн бус байгууллага юм. МБҮА ТББ нь Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн “УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН”, Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн холбоо (FIDIC)-ны “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)-ын УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮН” байгууллага юм.

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN





АЗИЙН БА БАРУУН НОМХОН ДАЛАЙН АССОЦИАЦИУДЫН ОЛОН УЛСЫН НИЙГЭМЛЭГ “IFAWPCA”-ИЙН 47 ДАХЬ ЧУУЛГАНААР МБҮА ТББ-ЫГ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР УЛИРААН БАТЛАМЖИЛЛАА.

IFAWPCA-ийн Ерөнхийлөгч Mr. Kenneth Loo:

Барилгын салбарт шинээр тулгарч буй сорилтуудыг хамтдаа туулцгаая

2025.04.07-11-ний өдрүүдэд IFAWPCA-ийн 47 дахь чуулганд Зүүн Өмнөд Азийн улс орнуудын төрийн байгууллагууд болоод барилга үл хөдлөх салбарын хөрөнгө оруулагчид, захиалагчид, барилгын материалын үйлдвэрлэгчид, ханган нийлэгчид, төсөл хэрэгжүүлэгчид гээд салбарынхан хуран чуулцаа.

Монгол Улсыг төлөөлж Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан “МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН САЛБАРЫН ӨНӨӨДӨР БА МАРГААШ...” илтгэлдээ Дэлхийн анхаарлыг зүй ёсоор татаж буй Оюу толгой, уран болон бодлогын шинж чанартай 14 мега төсөл хэрэгжих хүрээнд улс орныг хамарсан барилга бүтээн байгуулалтын томоохон ажлууд өрнөж байгааг дурдлаа.

Удирдах зөвлөлийн хурлын үеэр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь сүүлийн жилүүдэд маш хурдацтайгаар хөгжиж буй Төв Азийн улс орнуудыг IFAWPCA-ийн гишүүнчлэлд урих замаар хүрээгээ тэлэх боломж байгаа талаарх саналаа тавихаас гадна Гишүүн орнууддаа түгээдэг мэдээллийг улам хурдтай, хүртээмжтэй, өгөөжтэй болгох талаар саналаа хэлж хурлын гишүүдийн дэмжлэгийг авлаа.

Гишүүн орнуудын дунд хамтын түншлэл, харилцаа холбоогоо бэхжүүлэх, хамтарсан төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, ажиллах хүчний мэдээллээс гадна ажиллах хүчээ солилцох, сургах тал дээр ихээхэн идэвх санаачилга гарган ажиллахаар тогтлоо.

IFAWPCA-аас “INTERNATIONAL CONSTRUCTION BUSINESS MANAGEMENT” форумыг ирэх 10 дугаар сард Филиппин Улсад зохион байгуулж IFAWPCA-гийн гишүүн орнууд харилцан хамтран ажиллах, техник технологийн туршлагаа хуваалцах, харилцан суралцах, төсөл хөтөлбөрүүдэд хамтран ажиллах боломжуудын талаар чуулахаар тогтлоо.

“INTERNATIONAL CONSTRUCTION BUSINESS MANAGEMENT”

2025.04.07

2025.04.08

2025.04.09

2025.04.10

976-7011 1515
info@ mn
www.mnca.mn


TH IFAWPCA CONVENTION 2025
Embracing Construction of Tomorrow


47TH IFAWPCA CONVENTION
SINGAPORE 2025


47TH IFAWPCA CONVENTION
SINGAPORE 2025
1st Executive Board Meeting
Pro-Secretary General






RINA BAY SANDS
SINGAPORE


WELCOME TO SINGAPORE!






IFAWPCA

БНХАУ-ЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭЛЭГЧДИЙН ХОЛБОО МБҮА ТББ-ТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭХЭЭР ТОХИРЛОО



БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Холбоо (CHINCA)-ийн Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Үзэсгэлэн, хурал зохион байгуулах төвийн Ерөнхий захирал Mr. XU Guolei, Үзэсгэлэн, хурал зохион байгуулах төвийн Орлогч захирал Mr. ZHAO Shaobo, Бизнес эрхэлсэн менежер Mr. CHEN Tianhao МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайханыг CHINCA-ийн төв байранд 2025.04.15-ны өдөр хүлээн авч уулзан хоёр холбооны хамтын ажиллагааг улам өргөжүүлэх, өмнө нь ярилцсан асуудлуудыг ажил хэрэг болгох тал дээр санал солилцлоо.

Улмаар өмнөх уулзалтаар ярилцсан хоёр орны барилгын салбарын гишүүн байгууллагуудыг оролцуулсан үзэсгэлэнг ирэх 2025.08-р сард зохион байгуулахаар тохирч уг арга хэмжээнд БНХАУ-ын дэлхийд нэрд гарсан, нэр хүнд бүхий барилгын гүйцэтгэгчид, олон улсын гэрээлэгчид, барилгын ханган нийлүүлэгчид, үйлдвэрлэгчид, машин механизмын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгч гэх мэт 150 гаруй компаниудыг оролцуулахаар урьдчилсан төлөвлөгөөгөө танилцууллаа. Мөн уулзалтын үеэр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайханыг 2025.06.10-12-ны өдрүүдэд БНХАУ-ын Макаод болох ОЛОН УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА БАРИЛГЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ-д оролцох урилгыг гардууллаа. Уг IIICF нь олон улсын дэд бүтцийн хамтын ажиллагааны салбарт хамгийн том, нөлөө бүхий жил тутмын арга хэмжээ бөгөөд 70 гаруй улс орон, бүс нутгаас 3500 гаруй төлөөлөгч, түүнээс 60 гаруй нь төрийн сайдын түвшний төлөөлөгчид оролцдог дээд түвшний уулзалт юм.


НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАРТАЙ МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



НЗДТГ-аас зохион байгуулсан Барилгын ажил эхлэх зөвшөөрөл авах, архитектур төлөвлөлтийн даалгавар, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаа, барилгын хяналтын асуудлаар зохион байгуулсан арга хэмжээнд оролцож мэдээлэл авлаа. Мөн 2025 оны 4 дүгээр сарын 10-нд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х. Нямбаатартай уулзалт хийж Улаанбаатар хотын 2040 оны ерөнхий төлөвлөгөө, барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилгыг улсын комисст хүлээн авах

дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ярилцан, холбогдох саналаа албан бичгээр өгсөн болно.
Үр дүн: Энэ нь барилгын чанар, хяналтыг улам сайжруулах, барилгыг улсын комисст хүлээн авах асуудлыг боловсронгуй болгоход МБҮА ТББ-аас хийж байгаа нэг чухал алхам боллоо.

ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ НЭГЖТЭЙ МБҮА ТББ АЖИЛ ХЭРГИЙН УУЛЗАЛТЫГ ХИЙЛЭЭ



МБҮА ТББ нь Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран ажиллах хүрээнд удаа дараагийн уулзалтуудыг хийж байгаа бөгөөд 2025.04.14-ны өдрийн уулзалтаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх, Салбарын бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга М.Энхбаатар нар дараах асуудлыг хөндлөө.
Уулзалтаар төслөөс хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдэд Фидик-ийн гэрээний зарчмыг тусгах, төслийн нэгжийн ажилтнуудыг Фидик-ийн сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх, төслийн үйл явцын мэдээлэл болоод бусад арга хэмжээнүүдэд МБҮА ТББ-ын Гишүүдийг хамруулах зэрэг олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.

БНСУ-ын ХАНИЛ КОМПАНИЙН УДИРДЛАГУУДТАЙ МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД САНАЛ СОЛИЛЦЛОО



БНСУ-ын барилга, цементийн үйлдвэрлэл эрхэлдэг Hanil industrial ХХК-ийн Ерөнхий захирал Jung Uk-Jun, Ерөнхий менежер Lee Jonghoon болон бусад албаны хүмүүсийг МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх, Салбарын бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга М.Энхбаатар, Гадаад харилцааны менежер Ц.Нямдаваа нар хүлээн авч уулзлаа.
Hanil industrial ХХК-ийн төлөөлөгчид өөрсдийн үйл ажиллагаа, хэтийн төлөвлөгөө нь БНСУ-даа төдийгүй Азийн улс орнуудад хүрээгээ тэлж улмаар Монгол Улсад салбараа нээх, цар хүрээгээ тэлэх зорилгоор зах зээлийн төлөв байдал болоод хамтын ажиллагааны хүрээний талаар саналаа илэрхийлж цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал бодлоо солилцлоо.

2025



САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:



- Барилгын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн “Ажлын хэсэг”-т ХББОСЯ-нд зохион байгуулсан Хот байгуулалтын тухай хуулийн үзэл баримтлалын танилцуулга хийх уулзалт хуралд оролцсон.

Үр дүн: Барилгын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөлд 6 санал нэмж тусгахаар шийдвэрлүүлсэн нь МБҮА ТББ нь гишүүдийнхээ дуу хоолой болж хууль, төрийн бодлого, шийдвэрт санал бодлыг нь хүргэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулаа.

- СЭЗИС-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд МБҮА ТББ-ын дүрмийн шинэчилсэн төсөлд Гишүүдээс санал авах ажлыг 2025.04.30-ныг хүртэл зохион байгуулж Легал клиник ЮПЭ ХХК-аас санал авахаар ажиллаж байна.

Үр дүн: МБҮА ТББ-ын Дүрэм шинэчлэгдсэнээр үйл ажиллагааны хүрээ болон хамтын ажиллагааг өргөжүүлэх, гишүүдийн эрх, үүргийг тодорхой болгох, санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зэргээр байгууллагын ажиллагааг илүү үр дүнтэй, ил тод болгож, нийгэм болон гишүүдийнхээ эрх ашгийг илүү сайн хамгаалах, үйлчлэх боломжийг олгоно.

- Төслийн санхүүжилт, төлбөр тооцоог боловсронгуй болгоход банк, даатгал, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах, векселийн төлбөр тооцоог хэрэгжих боломжийг судалж, “Барилгын зах зээл 2025 арга хэмжээнд Мандал даатгал ХХК-ийн төлөөллийг урьж оролцогчдод “Барилгын салбарт хөрөнгө оруулалт босгох боломж” сэдвээр мэдээлэл илтгэлийг танилцуулав.

- “Их барилга – тооны хэлээр” цуврал видео контентыг 2025.02-р сараас шинээр хийж эхэлсэн бөгөөд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдрийг 2025.04.28-нд тэмдэглэхтэй холбогдуулан орон даяар зохион байгуулсан сарын аяны хүрээнд “Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдвээр судалгаа бэлтгэн, видео контент болгоход хамтран ажиллаж 4 сарын 25-ны өдөр нийтэд хүргэлээ.



- ГБХНХЯ-ны харьяа агентлаг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний 2023, 2024 оны мэдээлэл, ҮСХ-ноос гаргасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 2024 оны мэдээллийг цуглуулан мэдээллийг шинэчлэв. Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сэдэвт инфографик, судалгаа бэлтгэж, хотуудын түгжрэлд алдсан цаг хугацааны талаарх мэдээллийг бэлтгэн нийт гишүүдэд хүргэлээ.

- НЗДТГ-аас зохион байгуулсан Нийслэлд хэрэгжүүлэх 14 мега төслийн талаар танилцуулах арга хэмжээний зарыг нийт гишүүдэд хүргэн оролцохыг санал болгосон бөгөөд энэхүү арга хэмжээнд МБҮА ТББ-ын төлөөлөл оролцлоо.

Үр дүн: Гишүүн байгууллагуудыг албан ёсны тоон мэдээллээр хангахад чухал ажил болсон.

- Барилгын салбарын 12 ТББ МНХ байгуулах санамж бичигт гарын үсэг зурж хамтран ажиллаж байна. Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-т ажиллаж, 2025.04.09-ний өдөр Мэргэжлийн нэгдсэн холбоо, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага, тэдгээрийн ялгааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авлаа. Сургалтыг Монголын эрчим хүчний засаглалын хөтөлбөр USAID, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, MERI сангийн захирал Б.Мэндбаяр, ШУТИС-ийн багш, СисАрт Ахлах зөвлөх Ц.Мөнхтуяа нар хичээл заалаа.



Үр дүн: Ажлын хэсгийн гишүүд МНХ-ны талаар нэгдсэн ойлголттой болж цаашид нэгдсэн холбооны дүрмийн төсөл боловсруулах болон холбоогоо бүртгүүлэх бэлтгэл ажлуудыг хангахад илүү дөхөм, шуурхай болно.

- Түншлэгч төрийн бус байгууллагуудтай БҮАТЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах, бодлого боловсруулах, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд тавих хяналтыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулав.


ХАМТРАН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД:

Ажлын албанаас 2025.04.30-ны өдөр “Барилгын зах зээл 2025” форумын бэлтгэлийг ханган амжилттай зохион байгуулж, барилгын салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн компаниудын 160 гаруй төлөөлөгчдийг оролцууллаа. 2025.04.30-ны өдөр “Барилгын зах зээл 2025” форумын бэлтгэлийг ханган зохион байгуулахтай холбогдуулан ХББОСЯ, СЯ, ЭЗХЯ, ГБХНХЯ, БоЯ, ҮСХ руу хамтран ажиллах албан бичиг илгээж, тоо мэдээлэл авах, илтгэл тавих, панелистаар оролцуулах зэргээр оролцоог хангуулан ажиллалаа. Түүнчлэн МБҮА ТББ-ын илтгэл, хэлэх үг, зөвлөмжийн төсөл бэлтгэх, яамдтай ярьж илтгэгч, панелистуудыг томилуулах ажлыг хариуцан ажилласан.

Үр дүн: Энэхүү арга хэмжээ нь салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг олон талаас нь тунгаан ярилцах, шинэ мэдээлэл авах, салбарын мэргэжилтнүүд санал бодлоо илэрхийлэх боломж олгосноороо онцлог үйл явдал болсон.

- Барилгын салбарын идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудыг гишүүнчлэлээр элсүүлэх ажлын хүрээнд НАБХ, МХЦҮХ-ны удирдлагатай энэ асуудлаар ярилцлаа. Аймаг, орон нутагт МБҮА ТББ-ын салбар зөвлөл байгуулах ажлын хүрээнд Орхон аймагт салбар зөвлөл байгуулах хурлыг 2025.05.01-ний өдөр зохион байгуулж байна. Мөн Ховд, Баян-Өлгий, Дархан-Уул аймаг 2025.05.03-05-ны өдрүүдэд салбар зөвлөл байгуулах үүсгэн байгуулагчдын хурлыг зохион байгуулахаар бэлтгэлийг хангаад байна. Уг ажлыг Ажлын албаны Салбарын бодлого төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга М.Энхбаатар ахлан зохион байгуулж тус аймгуудад биечлэн оролцохоор боллоо. Гишүүнчлэлийн 2022-2024 оны татварын авлагатай 58 байгууллагаас авлагын хэмжээ ихтэй 13 байгууллагуудад онцгой анхаарч барагдуулахад хамтран ажилласан. Авлага барагдуулах ажлыг 5-р сард үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

2025



БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MCIS.GOV.MN


БҮАТЗХ-ИЙН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН ТОЙМ

БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 1000 гаруй ААНБ, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав.





БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай



зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг хүссэн 466 ААНБ-ын хүсэлт, материалыг баталгаажуулж, ХББОСЯ-нд 2025.04.03, 2025.04.10, 2025.04.17, 2025.04.24-ний өдрүүдэд тус тус цахимаар илгээв.

Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 1054 ААНБ-ын хүсэлт хянагдаж, 4 удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар 466 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав.

Үүнээс: Сунгалтаар 20, Нэмэлтээр 119, Шинээр 322, Дахин олгохоор 5 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Сунгалтаар 20 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 5, Нэмэлтээр 119 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 104, Зураг төсөл боловсруулалтаар 13, Өргөх байгууламжаар 22, Шинээр 466 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 322, Зураг төсөл боловсруулалтаар 39, Өргөх байгууламжаар 11, дахин олгохоор 5 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 5 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Эдгээр 4 удаагийн баталгаажуулалтаар давхардсан тоогоор 519 ААНБ-ын материалыг шаардлага хангаагүйн улмаас буцааж, 48 ААНБ-ын хүсэлтийг шалгахаар хүлээгдэж байна.

- Журмын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 466 ААНБ-ын материалыг хянаж, 2092 инженер, техникийн ажилтнуудын баталгаажуулалтыг хийв.
- Монгол Улсын Засгийн газрын “Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал”-д нийтлэх БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, 4 удаа ХББОСЯ-нд хүргүүлэв. Улсын бүртгэлийн ерөнхий газрын *opendata.burtgel.gov.mn*-д БУ: 4,580, ЗТ: 913, ӨБ: 164 ААНБ-ын нийт 5,657 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- БҮАТЗ-тэй ААНБ-уудын мэдээллийн санг үүсгэн *www.mcis.gov.mn*-ын “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 4,580, ЗТ: 913, ӨБ: 164 ААНБ-ын нийт 5,657 ААНБ-ын мэдээллийг 5 удаа нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд БУ: 116, ЗТ: 24, ӨБ-1 ААНБ-ын мэдээллийг илгээв.
- ХББОС-ын Сайдын тушаалыг үндэслэн 420 ААНБ-тай гэрээг байгуулж, Засгийн газрын “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тогтоолын дагуу 391,250,000 төгрөгийн Улсын тэмдэгтийн хураамжийг Худалдаа, хөгжлийн банкны дансанд төвлөрүүлэв.
- Үйлчилгээний хөлсний 466 ААНБ-ын 273,130,000 төгрөгийг Худалдаа, хөгжлийн банкны 431006029 тоот дансаар төвлөрүүлэн ажиллав.

ХББОС-ын Сайдын 2025.04.01-ний өдрийн тушаал №70, Сайдын 2025.04.04-ний өдрийн тушаал №73, Сайдын 2025.04.11-ний өдрийн тушаал №76, Сайдын 2025.04.16-ны өдрийн тушаал №79 дүгээ тушаалыг үндэслэн 445 ширхэг үнэт цаасанд бичилтийг хийж, баталгаажуулав.

2025

ГИШҮҮНЧЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилт, 2025 онд хэрэгжүүлэх Гишүүнчлэлийн мега төслийн хүрээнд гишүүнчлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулан хүргэхээр мэдээлэл постер бэлтгэн холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд **2025.04-р сард 4 байгууллагыг гишүүнээр элсүүлэв**. Үүнд: Гишүүнээр барилга угсралт, барилгын материал худалдаа, үйлдвэрлэлийн БОДЬ ПРОПЕРТИЙЗ ХХК, БЛЬЮ РАЙГЕЛЬ ХХК болон JUFU IMPORT AND EXPORT LLC, JUFU IMPORT AND EXPORT LLC нар Ажиглагч гишүүнээр элслээ.

МБҮА ТББ нь Олон улсын болон дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран гишүүн байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах **СУРГАЛТ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ** зохион байгуулах зорилгын хүрээнд **PMI Mongolia Chapter** буюу Төслийн Удирдлагын Институттэй хамтран "PMI - Төслийн удирдлагын үндэс" сэдвийн хүрээнд **БАРИЛГЫН ТӨСЛИЙГ ХЭРХЭН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ВЭ? Онол, практикийг хослуулсан сургалтын** сургагч багш, хөтөлбөр боловсруулах зэрэг зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна. Сургалт нь **Төслийн удирдлагын олон улсын стандартад суурилсан** бөгөөд оролцогчдыг мэргэжлийн түвшинд чадваржуулахад чиглэж байна.

Сургалтын гол агуулгууд:

- ✓ **Төслийн удирдлагын үндэс:** Төсөл, хөтөлбөр, портфолио, уламжлалт ба Agile аргачлалын ялгаа
- ✓ **Төлөвлөлт ба хэрэгжилт:** Шаардлага тодорхойлох, хугацаа, төсөв, эрсдэлийг төлөвлөх, гэрээ, худалдан авалт
- ✓ **Гүйцэтгэл ба хяналт:** Төслийн хэрэгжилтийн хяналт, гүйцэтгэлийн хэмжилт
- ✓ **Хаалтын үе шат:** Сургамж дүгнэх, тайлагнах, мэдлэгийн сан бүрдүүлэх зэрэг болно.



Монголын барилгын салбарын хөгжил, эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой МБҮА ТББ нь үндэсний барилгын компаниудын нэгдэл болохын хувьд нийслэл төдийгүй орон нутагт үйл ажиллагаагаа өргөжүүлж 21 аймагт салбар зөвлөл байгуулахаар 4-р сард идэвхжүүлэлт хийн Ховд, Баян-Өлгий, Дархан-Уул аймгуудад салбар зөвлөлийг байгуулах ажил үргэлжилж байна.





“BARILGA EXPO 37” ДАХЬ ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГТ МБҮА ТББ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТАНИЛЦУУЛЛАА

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, гишүүнчлэлийг нэмэгдүүлэх зорилгоор барилгын салбарынхан буюу барилгын материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэгч, хөрөнгө оруулагч, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчид нэгэн дор цуглардаг “BARILGA EXPO 37” дахь удаагийн барилгын үзэсгэлэн яармагт МБҮА ТББ нь барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн шинэ суурь нөхцөл, шаардлага болоод хэрхэн хөнгөвчлөгдсөн талаарх мэдээллийг олон нийтэд танилцуулахаас гадна Гишүүдэд чиглэсэн арга хэмжээ, Дулаан шийдэл төслийн талаар дэлгэрэнгүй мэдээ мэдээллийг өгч ажиллав.

Үр дүн: Тус арга хэмжээнд танилцуулагдах баннер, стенд, макет зэрэг 10 гаруй эх дизайн дээр ажиллан боловсруулж хэвлэлтийн дизайн дээр ажиллав. Мөн байгууллагын товч танилцуулга, БҮТЗХ-ийн үйл ажиллагааны зэрэг брошурын эхийг бэлдэн тус арга хэмжээнд нийт 500 гаруй брошурыг тараан үйл ажиллагааг сурталчлан ажиллан ажилласан бөгөөд гишүүнээр элсэх сонирхолтой 6 байгууллагад холбогдох мэдээллийг дахин өгөн гишүүнчлэлээр элсүүлэх ажил үргэлжилж байна.

МБҮА ТББ-ын ДЭРГЭДЭХ АРБИТРЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

МБҮА ТББ дэргэдэх Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитр нь Арбитрчийн чиг үүргийг хараат бусаар, ёс зүйтэй, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж чадах иргэдийг нээлттэй зарчмаар сонгон шалгаруулж жагсаалтад бүртгэх ажил үргэлжилж байна.

БАРИЛГЫН ТӨСЛИЙН ФИДИК-ИЙН ЖИШИГ ГЭРЭЭ СЭДЭВТ СУРГАЛТЫГ 2 ДАХЬ УДААГАА ЗОХИОН БАЙГУУЛАВ

МБҮА ТББ нь Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК)-нд ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН-ий хувьд Монгол Улсын барилгын салбарт олон улсын гэрээ, эрх зүйн орчныг стандартын дагуу хэрэгжүүлэх, шинэ дэвшил, эргэлтийг авчрах таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2025.04.24-ний өдөр салбарын мэргэжилтнүүдэд барилгын төслийн гэрээ ФИДИК-ИЙН ЖИШИГ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ-үүд сургалтыг зохион байгууллаа.

Үр дүн: Уг сургалтад төр болоод хувийн хэвшлийн салбарын инженерүүд, хуульчид, захирлууд зэргийн 33 хүн хамрагдсанаас МБҮА ТББ-ын 4 гишүүн байгууллагын 6 төлөөллүүд хамрагдлаа. Түүнчлэн МБИХ-оос гэрээний дагуу 25 инженерт багц цаг олгуулав.

"БАРИЛГЫН ЗАХ ЗЭЭЛ 2025" СЭДЭВТ ФОРУМ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал барилга, бүтээн байгуулалтын салбарт хэрхэн нөлөөлж буй болоод, барилгын зах зээлийн нөхцөл байдал, санхүүжилт, хөрөнгө оруулалт болон судалгааны нэгдсэн мэдээ, мэдээллийг хүргэх "CONSTRUCTION MARKET–2025" форумыг Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамтай хамтран 2025.04.30-ны өдөр Туушин зочид буудлын Соёмбо танхимд зохион байгууллаа.

Үр дүн: Тус арга хэмжээнд 160 гаруй хүн оролцсоноос 20 гаруй нь Ассоциацийн гишүүн байгууллагууд оролцсон бөгөөд үлдсэн 140 гаруй байгууллагуудыг мэдээллийн санд бүртгэлжүүлэн гишүүнчлэлийг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн ажиллаг байна.


С.Темүүлэн
Н.Баярсайхан


МБУА


МБУА
CONSTRUCTION
MARKET 2025
FORUM


МБУА


МБУА
2025
FORUM
CONSTRUCTION
MARKET





МБУА
ЭРЭЛТ
2025
FORUM


МБУА
CONSTRUCTION
MARKET






ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ
МБУА
МОНГОЛЫН БАРИЛГЫН
УНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009









“TURKEY BUILD-2025” ҮЗЭСГЭЛЭН ЭКСПО-Д МБҮА ТББ НЬ 20 ГИШҮҮН БАЙГУУЛЛАГАА ХАМРУУЛЛАА

2025.04-15-17











МБҮА ТББ БНТУ-ЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБООТОЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦОВ

2025

“ДУЛААН ШИЙДЭЛ2" төсөл



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.DULAALGA.MN

"ДУЛААН ШИЙДЭЛ II" ТӨСЛӨӨС ЧАДАВХЖСАН БАРИЛГЫН САЛБАРЫН БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА









"ДУЛААН ШИЙДЭЛ II" төслийн зүгээс 2024 оны намрын элсэлтийн чадавхжуулах багц хөтөлбөрт бүрэн хамрагдсан, цаашид дулаалгын зөвлөхөөр ажиллах сонирхолтой 8 барилгын салбарын бизнес эрхлэгчдэд дулаалгын ажил хийж гүйцэтгэх зөвлөмж, МБҮА ТББ-ын зүгээс хамтран ажиллахад анхаарах зүйлсийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч, хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ЗҮҮН АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС ХАРИУЦСАН УДИРДЛАГУУД “ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАРЬСАН ЗАГВАР СУУЦ БОЛОН ДУЛААЛСАН БАЙШИНТАЙ ТАНИЛЦЛАА

Европын Холбооны Олон улсын хамтын ажиллагааны газрын Зүүн Ази, Номхон далайн бүс хариуцсан Ерөнхий захирал Сара Риналди, Европын Холбооноос Монгол улсад суугаа төлөөлөгчийн газрын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Адриен Мург, болон төслийн менежер







Бямбарагчаа тэргүүтэй зочид төлөөлөгчид Европын Холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийн хүрээнд барьсан “Тэг эрчим хүчний загвар сууц”-тай 2025.04.05-нд танилцлаа. Төлөөлөгчид мөн Бодь Пропертийз ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн “Дулаан байшин, тухтай амьдрал” кампанит ажлын хүрээнд бүрэн дулаалсан байшинтай өрхийнд зочлон, дулаалгын ашиг тус, дулаалахаас өмнөх болон дараа гарсан өөрчлөлтүүдтэй танилцлаа. Тухайн өрх дулаалга хийлгэхээс өмнө цан цохих, хөгц үүсэх, ханын цаас хуулрах зэрэг бэрхшээл тулгардаг байсан бөгөөд дулаалга хийлгэсний дараагаар тус асуудлууд ахин гараагүй, хүүхдүүд хөл нүцгэн тоглоход даарахааргүй тухтай болсныг онцлов.

"ДУЛААН ШИЙДЭЛ II ТӨСЛИЙН БАГЦ ЧАДАВХЖУУЛАХ ХӨТӨЛБӨР"-ИЙН ХҮРЭЭНД ХАВРЫН ШИНЭ ЭЛСЭЛТИЙН "БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД" 6 ТӨРЛИЙН СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

“МАРКЕТИНГИЙН” СУРГАЛТ



“Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв”-өөс 2025.03.24-28-ны өдрүүдэд зохион байгуулсан "Дулаалгын технологи, дулаан хамгаалалтын үнэлгээ" сургалтад хамрагдсан хаврын шинэ элсэлтийн барилгын салбарын бизнес эрхлэгчиддээ зориуллаа.

Эзэмшүүлсэн мэдлэг, мэдээлэл: Зах зээлд суурилсан төсөл гэж юу вэ? Төслийн маркетингийн сувгууд, “Дулаан шийдэл” төслийн бүтээгдэхүүн үйлчилгээ, дулаалга хийхэд тулгардаг асуудлууд, төслийн онцлог давуу тал, амжилттай борлуулалт хийх аргачлал- амжилттай борлуулалт хийхийн тулд хэрэглэдэг 5 шатлалд арга (борлуулалтын стратеги), кэйс ажиллагаа- хэцүү хэрэглэгчтэй хэрхэн харилцах талаар ойлголт гэх мэт

"БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ" СУРГАЛТ

Огноо: 2025.04.07
Зохион байгуулагч: МБҮА ТББ
Хамтран зохион байгуулагч: ШУТИС-ийн Барилга архитектурын сургууль
Хамрагдсан хүний тоо: 24

Эзэмшүүлсэн мэдлэг, мэдээлэл: Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө



боловсруулах, хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах тухай

“БАРИЛГЫН САЛБАРЫН ЖЕНДЕРИЙН АСУУДАЛ ШИЙДЭЛ” СУРГАЛТ



Огноо: 2025.04.07
Зохион байгуулагч: МБҮА ТББ
Хамтран зохион байгуулагч: Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэн
Хамрагдсан хүний тоо: 25
Эзэмшүүлсэн мэдлэг, мэдээлэл: Жендэрийн үндсэн ойлголт, Хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн

эрх тэгш байдал, Барилга, хот байгуулалтын салбарт жендерийн талаар баримтлах бодлого, Барилгын салбарын бизнес эрхлэгчдэд тулгардаг жендэрийн асуудал, шийдвэрлэх арга зам

“НИЙТ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ХАБЭА” СУРГАЛТ







Огноо: 2025.04.08
Зохион байгуулагч: МБҮА ТББ, ЭН СИ ДИ ГРУПП ХХК
Хамрагдсан хүний тоо: 24
Эзэмшүүлсэн мэдлэг: ХАБЭА-ийн тухай ойлголт, хамаарах асуудал, хөдөлмөрийн гэрээ мөрдөгдөж буй хууль тогтоомж, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тухай ойлголт, даатгал, тусламж, үйлчилгээ мөн ажилтан гэлтгүй иргэн бүр өөрийн ажлын байран дахь эрсдэлээ өөрөө зөв үнэлэх, хариуцлагатай, ухамсартай байх, эрсдэл үүссэн тохиолдолд авах боломжит хариу арга хэмжээний талаарх мэдээлэл гэх мэт

“УДИРДАХ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ХАБЭА-Н” СУРГАЛТ

Огноо: 2025.04.09
Зохион байгуулагч: МБҮА ТББ, ЭН СИ ДИ ГРУПП ХХК
Хамрагдсан хүний тоо: 24
Эзэмшүүлсэн мэдлэг: ХАБЭА-ийн тухай ойлголт, хамаарах асуудал, хөдөлмөрийн гэрээ мөрдөгдөж буй хууль тогтоомж, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тухай ойлголт, даатгал, тусламж, үйлчилгээ мөн ажилтан гэлтгүй иргэн бүр өөрийн ажлын байран дахь эрсдэлээ өөрөө зөв үнэлэх, хариуцлагатай, ухамсартай байх, эрсдэл үүссэн тохиолдолд авах боломжит хариу арга хэмжээний талаарх мэдээлэл гэх мэт


"КОМПАНИЙХАА СТРАТЕГИЙГ ТОМЪЁОЛОХ НЬ" СЭДЭВТ БИЗНЕС СУРГАЛТ







Огноо: 2025.04.16
Зохион байгуулагч: “МБҮА” ТББ.
Хамтран зохион байгуулагч: “Ганабелл институт”
Хамрагдсан хүний тоо: 27
Эзэмшүүлсэн мэдлэг: Оролцогчдыг компанийхаа стратегийг системтэйгээр тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх үндсэн ойлголт аргачлалаар хангаж, компанийхаа алсын хараа үнэт зүйлс, стратеги зорилгыг тодорхойлох чадвар эзэмшүүлэх,



Асуулт 7. Сургалтаас цаашид өөрийн ажилдаа/ амьдралдаа хэрэглэж болохуйц бодит ажил болгох ямар санаа олж авсан бэ? Өөртөө төрсөн санаанаасаа хуваалцана уу?

Хариулсан хүний тоо	Хариулт
4	Зөв зүйл сурсан ажил болгоноо.
4	5 5-н зарчим санааг мэдэж авлаа.
1	Системийг ажилдаа авч хэрэгжүүлэх санаа авлаа.
5	Бусдаас өөрөөр сэтгэж, хэрэглэгчээ ойлгох хэрэгтэй.
1	Бизнес модель ойлгосон.
1	Хувиргах чадвартай байх
1	Өөрийн бизнесээс гадна шинэ орлого олох шинэ бизнесийн санаа оллоо.

Асуулт 8. Энэхүү сургалтаас гадна ямар төрлийн сургалт авахыг хүсч байна вэ?

№	**Дулаалгын зөвлөхүүд эдгээр сургалтыг авахыг сонирхож байна.**
1	Компанийн стратегийн сургалт
2	Сүүлийн үеийн технологийн сургалт
3	Удирдагч хүний чиг үүрэг
4	Хувь хүний хөгжил илтгэх урлаг
5	Бизнес төлөвлөгөө боловсруулах

Асуулт 9. Сургалтын чанарыг сайжруулах таны санал:

- ✓ Бодит кейстэй оруулах
- ✓ Сургалтын чанар маш сайн байна.
- ✓ Цаг хугацааг жаахан шахуу болгох
- ✓ Кейс ажиллах хугацааг уртасгах
- ✓ Сургалтыг дэлгэрэнгүй урт хугацаанд орох

“BARILGA EXPO 37” ДАХЬ ҮЗЭСГЭЛЭНД "ДУЛААН ШИЙДЭЛ II ТӨСӨЛ" ТАНИЛЦУУЛГА, ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЭЛ ӨГЧ ОРОЛЦЛОО

Барилгын салбарынхан буюу барилгын материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэгч, хөрөнгө оруулагч, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчид нэгэн дор цуглардаг “BARILGA EXPO 37” дахь удаагийн барилгын үзэсгэлэн яармаг зохион байгуулагдсан бөгөөд МБҮА ТББ-ийн "ДУЛААН ШИЙДЭЛ II төсөл"-ийн баг болон 10 дулаалгын зөвлөхүүд хамтран төслийн талаарх дэлгэрэнгүй танилцуулга, зөвлөгөө мэдээлэл өгч оролцсон ба Үзэсгэлэн худалдааг сонирхон ирсэн хүүхдүүдийн дунд “АХА” тэмцээн өрнүүлж нийт 45 хүүхдэд



гарын бэлэг өглөө. Мөн 3 өдрийн үзэсгэлэн яармагт төслийн танилцуулга 1200 брошюр тараагдсан байна.

ТӨРИЙН БАНКНААС ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-НОГООН ИРЭЭДҮЙ” ҮЗЭСГЭЛЭНД "ДУЛААН ШИЙДЭЛ II ТӨСӨЛ" НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ ӨГЧ ОРОЛЦЛОО



Ногоон хөгжлийг дэмжигч Төрийн банкнаас “Тогтвортой хөгжил-Ногоон ирээдүй” үзэсгэлэн худалдааг хоёр дахь жилдээ зохион байгуулж байна. Тус үзэсгэлэн худалдаа нь байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээхэд чиглэсэн төдийгүй салбарын мэргэжилтнүүд тулгамдаж буй асуудлуудаараа бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэн, илтгэл тавьж, олон нийтийн асуултад нээлттэй хариулан зөвлөгөө өгдгөөрөө онцлогтой юм. МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл- II төсөл”-ийн баг нээлттэй мэдээлэл өгч оролцлоо.

"ДУЛААН ШИЙДЭЛ II ТӨСӨЛ"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ 5 БАЙГУУЛЛАГЫН УУЛЗАЛТАД ОРОЛЦЛОО







"Дулаан шийдэл II төсөл"-ийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хооронд 14 хоног тутамд онлайн уулзалт зохион байгуулагддаг бөгөөд уулзалтаар тухайн хоёр долоо хоногтоо хийгдсэн ажлын тайлан мэдээ болон ирэх хоёр долоо хоногт хийгдэхээр төлөвлөгдсөн ажлын мэдээлэл солилцдог билээ. Үүний хүрээнд энэ удаагийн уулзалтыг "ЖЭРЭС" ОУТББ биет хэлбэрээр зохион байгуулсан. Мөн уулзалтаар төслийн нөлөөллийн үнэлгээний судалгааны тайланг танилцууллаа. Судалгаанд 585 айл өрх хамрагдсан ба 47% дулаалгагүй, 27% хагас дулаалгатай, 26% нь бүтэн дулаалгатай байв. Судалгааны үр дүнгээс харахад Дээврийн дулаалга нь бие болон сэтгэл зүйн эрүүл мэндэд эерэгээр нөлөөлдөг бөгөөд байшингийн тав тухтай байдал, үнийн талаарх үзэлд мөн эерэг нөлөө үзүүлдэг байна. Нөлөөллийг дулаалгагүй өрхийн дундажтай харьцуулсан хувиар тооцоход: 1. Биеийн эрүүл мэндийн байдал 14%-иар сайн, 2. Сэтгэл зүйн эрүүл мэндийн байдал 19.2%-иар илүү, 3. гэр доторх дулаанд сэтгэл хангалуун гэсэн хувь 16.5%-иар илүү, Байшингийн үнэ сүүлийн нэг жилд өссөн гэж хариулсан хувь 11.3 %-иар илүү гэсэн үр дүн гарсан. Нөлөөллийн судалгааг Эн ар си си хийж гүйцэтгэсэн байна.

"ДУЛААН ШИЙДЭЛ II ТӨСӨЛ"-ИЙН "ДУЛААЛГЫН ХЯЛБАР ШИЙДЭЛ"-АЯНЫ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ



Европын Холбооны "Свич-Эшиа" хөтөлбөрийн санхүүжилттэй "Дулаан шийдэл" төслийн хүрээнд айл өрхүүдэд дулаалгын ач холбогдлын талаарх ойлголт өгөх, гарын доорх материалаар байшин сууцаа дулаалах хялбар шийдлүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор олон нийтийн оролцоог хангах кампанит ажлыг "Дулаалгын хялбар шийдэл" аян нэртэйгээр хэрэгжүүлдэг бөгөөд "Дулаалгын хялбар шийдэл" аяныг хэрэгжүүлэгч байгууллагуудын дундах туршлага солилцох уулзалтад мэдээлэл авах зорилгоор "Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ"-ын "Дулаан шийдэл" төслийн багийн төлөөлөл оролцлоо.

Оролцогчид:

- "НЗДТГ"-аас Агаар орчны бохирдлыг бууруулах хэлтэс болон сургалт хөгжлийн хэлтсийн төлөөллүүд,
- СХД, СБД, ЧД, БЗД, БГД, ХУД-үүдийн агаар орчны бохирдол хариуцсан ажилчид,
- Амины орон сууц, инновац хөгжлийн төвийн захирал
- Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ
- Монголын эмэгтэйчүүдийн сан,
- Дулаан шийдэл төслийн олон нийтийн оролцоо хариуцсан ажилтнууд оролцлоо.

"ДУЛААН ШИЙДЭЛ-2 ТӨСӨЛ"-ИЙН БАГИЙН 4-Р САРД

ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/Д	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ТООН ҮЗҮҮЛЭЛТ
1.	ББЖБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	116
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан ББЖБЭ-ийн тоо	24
3.	ББЖБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	35
4.	ББЖБЭ-дэд зуучилсан дулаалгын ажлын тоо	1
5.	ББЖБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	6
6.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон ББЖБЭ-ийн тоо	31
7.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн ББЖБЭ-ийн тоо	8
8.	Техникийн үнэлгээ, дулаалга болон барилгын ажлын талаар гарсан санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн харилцагчдын тоо	13
9	Техникийн үнэлгээний дадлага хариуцсан Бригадын ахлагчийн тоо	4
10	Техникийн үнэлгээний дадлагад гарсан ББЖБЭ-ийн тоо	23

МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

БАЙГУУЛЛАГЫГ СУРТАЛЧЛАХ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХҮРЭЭНД:







www.mnca.mn

ТУХАЙН САРД АРГА ХЭМЖЭЭНИЙ РИЙЛС 21 :



ТУХАЙН САРД ПОДКАСТ ЯРИЛЦЛАГА, КОНТЕНТ-2







МБУА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn